



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 11518

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Гамшгийн хохирлыг барагдуулах зарим арга хэмжээний тухай" 72 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр, Баянгол, Нарийнтээл, Тарагт, Уянга, Хайрхандулаан Хужирт сумдын нутаг дэвсгэрт 2018 оны 7 дугаар сард болсон үерийн улмаас учирсан айл өрхийн хохирлыг арилгах зардал, мал эмнэлэгийн албан алба хаагчдын томилолт, нөхөн төлбөр, засварын зардлын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх сумдын нутаг дэвсгэрт 2018 оны 7 дугаар сард болсон үерийн улмаас учирсан айл өрхийн хохирлыг арилгах, мал эмнэлэгийн газрын алба хаагчдын томилолт, бусад зардал, нөхөн буцалтгүй тусламжийг зохих журмын дагуу зарцуулахыг Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Эрдэнэбат)-т даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хавсралтад заагдсан 80.000.000 (наян сая) төгрөгийн зарцуулах эрх олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100908

Аймгийн Засаг даргын 2019... оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар захирамжийн хавсралт



ӨВӨХРАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР, БАЯНГОЛ, НАРИЙНТЭЭЛ, ТАРАГТ, УЯНГА, ХАЙРХАНДУЛААН ХУЖИРТ СУМДЫН НУТАГ ДЭВСГЭРТ 2018 ОНЫ 7 ДУГААР САРД БОЛСОН ҮЕРИЙН УЛМААС УЧИРСАН АЙЛ ӨРХИЙН ХОХИРЛЫГ АРИЛГАХ ЗАРДЛЫН ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Овог нэр	Хэмжих нэгж	Мөнгөн дүн	Тайлбар
1	Зүүбаян-Улаан	Ш.Батсүх	Төгрөг	10.000.000	Арвайхээр, Баянгол, Нарийнтээл, Тарагт, Уянга, Хайрхандулаан Хужирт сумдын нутаг дэвсгэрт 2018 оны 7 дугаар сард болсон үерийн улмаас учирсан айл өрхийн хохирлыг арилгах зардал
2	Зүүнбаян-Улаан	Р.Цэрэнбал	Төгрөг	6.000.000	
3	Арвайхээр	Ч.Эрдэнэбаяр	Төгрөг	3.000.000	
4	Арвайхээр	Б.Гөлөгтөмөр	Төгрөг	2.000.000	
5	Арвайхээр	Н.Гүндсамба	Төгрөг	5.000.000	
6	Тарагт	Ш.Бат-эрдэнэ	Төгрөг	5.000.000	
7	Нарийнтээл	О.Наранбаатар	Төгрөг	5.000.000	
8	Нарийнтээл	Д.Батдорж	Төгрөг	8.000.000	
9	Арвайхээр	Б.Лхагвасүрэн	Төгрөг	1.000.000	
10	Мал эмнэлгийн газар		Төгрөг	8.838.000	Мал, амьтаны гоц халдварт шүлхий өвчны үед ажилласан алба хаагчдын томилолт
11	Онцгой байдлын газар		Төгрөг	6.162.000	Бусад зардал
12	Д.Бэхбат		Төгрөг	20.000.000	Шүлхийн постонд үүрэг гүйцэтгэж яваад нас барьсан Б.Өлзийбаярын аав Бэхбатад буцалтгүй тусламж
НИЙТ ДҮН				80.000.000.00	